



ДАРХАН - ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР
ОНӨААТҮГ-ын ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 106

Дархан

ИТА, албан хаагчдын ажлыг дүгнэх,
ур чадварын нэмэгдэл олгох
журам батлах тухай

Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх заалт, 108 дугаар зүйлийн 108.1 дэх заалт, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид урд чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг жишиг болгон, "Дархан хот байгуулалт барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, 4.1.11 дахь заалт, байгууллагын дотоод журмын 7 дахь хэсгийн 7.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- Тус газрын "ИТА, албан хаагчийн ажлыг дүгнэх, ур чадварын нэмэгдэл олгох журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "ИТА, албан хаагчийн ажлыг дүгнэх хуудас"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Энэ тушаалыг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаандaa мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ИТА, албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАТБАЯР





“Дархан-Хот байгуулалт, барилга захиалагчийн газар”
ОНӨААТҮГазрын даргын 2023 оны 02
дугаар сарын 01-ний өдрийн 106дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР”
ОНӨААТҮГ-ЫН ИТА, АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫГ ДҮГНЭХ,
УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

1.1 Энэхүү журмаар тус газарт ажиллаж буй ИТА, албан хаагчийн ажлыг дүгнэж, ур чадварын нэмэгдэл олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 ИТА, албан хаагчийн ажлыг дүгнэж, ур чадварын нэмэгдэл олгоход Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГазрын дотоод журам болон энэхүү журмыг баримтална.

1.3 Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг нормоос давсан үзүүлэлттэй, тулгамдсан бэрхшээл, тооцоологдоогүй ажилд идэвх санаачилга гарган мэргэжлийн ур чадвар гарган асуудлыг шийдвэрлэсэн үр дүнтэй ажиллаж байгаа албан хаагчдад тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу ажлыг нь дүгнэсний үндсэн дээр ур чадварын нэмэгдэл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

1.4 Албан хаагчийн ажлыг дүгнэх эрх бүхий албан тушаалтан нь шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримталж, албан хаагчийн ажлыг тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу бодитой, үнэн зөв дүгнэнэ.

Хоёр. ИТА, албан хаагчийн ажлыг дүгнэх.

2.1 ИТА, албан хаагчийн ажлыг сар бүр дүгнэж, уг үнэлгээг үндэслэн сарын сүүл цалинд нэмэгдлийг олгох эсэхийг шийдвэрлэнэ.

2.2 ИТА, албан хаагчийн ур чадварын нэмэгдлийг газрын дарга дүгнэнэ.

2.3 ИТА, албан хаагч нь “ИТА албан хаагчийн ажлыг дүгнэх хуудас”-ны дагуу ажлын гүйцэтгэлийг сарын бүрийн 24-ний дотор гаргаж газрын даргад тайлагнана.

2.4 Газрын дарга нь албан хаагчийн ажлыг тайлагнаас хойш 1 өдрийн дотор үнэлгээний хуудсаар дүгнэж, холбогдох албан хаагчид танилцуулан баталгаажуулж, санхүүд хүргүүлнэ.

2.5 Ур чадварын нэмэгдлийг газрын даргын шийдвэрээр олгоно.

2.6 Газрын дарга нь албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох, үнэлгээг өөрчилж, ур чадварын нэмэгдэл олгохгүй байж болно.

Гурав. Ур чадварын нэмэгдэл олгох

3.1 Албан хаагчийн сарын ажлыг "ИТА албан хаагчийн ажлыг дүгнэх үнэлгээний хуудас"-д заасан шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

3.2 Ур чадварын нэмэгдлийг албан хаагчийн албан тушаалын нэг сарын үндсэн цалингийн 10-25 хүртэл хувиар тооцож олгоно.

3.3 Энэ журмын 3.2-т заасан ур чадварын нэмэгдлийг тухайн ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн дараах аргачлалаар тооцож олгоно. Үүнд:

3.3.1 95-100 оноо авсан бол ур чадварын нэмэгдлийг 25%;

3.3.2 90-94 оноо авсан бол ур чадварын нэмэгдлийг 20%;

3.3.3 85-89 оноо авсан бол ур чадварын нэмэгдлийг 15%;

3.3.4 80-84 оноо авсан бол ур чадварын нэмэгдлийг 10%;

3.4 Дараах тохиолдолд ур чадварын нэмэгдлийг олгохгүй.

3.4.1 ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр 0-79 оноо авсан бол;

3.4.2 нэг сард ажлын 15-аас дээш хоногийн хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байсан бол тухайн сард;

3.4.3 туршилтын хугацаагаар ажиллаж буй ажилтанд;

3.4.4 хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээ байгуулан ажиллаж буй иргэнд буюу гэрээт ажилтанд;

3.4.5 тухайн сарын ажлын ачаалал, гүйцэтгэл, үр дүнг харгалzan олгохгүй байж болно;

Дөрөв. Бусад

4.1 ИТА, албан хаагч нь жилийн эхэнд гүйцэтгэлийн төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулах ба сар бүр, улирал бүр, хагас болон бүтэн жилээр гүйцэтгэлийн тайлан гаргаж газрын даргаар үнэлүүлнэ.

4.2 Газрын дарга нь үр дүнгийн урамшууллыг дотоод журамд заасны дагуу ИТА, албан хаагчдад 40 хүртэл хувиар олгоно.

"Дархан-Хот байгуулалт, барилга захиалагчийн газар"
ОНЕААТГУГАЗРЫН дартын 2023 оны 06-р
дугаар сарын 06-ний өдрийн 10:00 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР” ОНЕААТГУГАЗРЫН ИТА, АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫГ ДҮГНЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Ерөнхий мэдээлэл:

- Овог, нэр:
- Албан тушаал:
- Тайлант хугацаа:

№	Шалгур узүүлэлт Биелэлт	Шалгур узүүлэлтэд өгөх дээд оноо	Газрын даргын үнэлгээ
	Нэг. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажлын байрны гол үйл ажиллагааны хэрэгжилт	Нийт авах дээд оноо 40 оноо	
1.1	Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ бүрэн гүйцэд, чанартай хэрэгжүүлсэн байх.	40 хүртэл оноо	
	Хоёр. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар буюу төлөвлөгөөт бус ажлын биелэлт	Нийт авах дээд оноо 30 оноо	
2.1	Өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн гүйцэд чанартай биелүүлсэн байх. Хэд хэдэн үүрэг даалгавар өгсөн тохиолдолд тус тусад нь дүгнэж, оноог нэгтгэн гаргана.	Өгсөн үүрэг даалгаврын хугацаанд нь бүрэн гүйцэд чанартай биелүүлсэн бол Өгсөн үүрэг даалгаврын хугацаа хэтрүүлсэн боловч	30 оноо 20 хүртэл оноо

		Бүрэн биелүүлсэн, эсхүл бүрэн биелүүлсэн боловч чанар, үр дүн хангалтгүй бол.	
		Бүрэн бус биелүүлсэн, хугацаа хэтээрч байгаа бол ажлын явц үр дүнг харгалзан	15 хүртэл оноо
		Огт биелүүлээгүй бол.	0
Гурав. Ажлын цаг ашиглалт			
3.1	Ажлын цагийг үр бүтээлтэй, бүрэн ашиглаж ажлын цагаар үүрэгт ажилд холбогдогүй үйл ажиллагаа явуулдаггүй байх, ажлын цагаас хоцроогүй, ажил таслаагүй, ажлын цагийн бүртгэл бүрэн, хундэтгэн үзэх шалтгаан гарсан тохиолдолд газрын удирдлагад урьдчилан мэдэгдэж чөлөө авдаг байх, чөлөөний өргөдөл, эмнэлгийн магадлагаа зэргийг тухай бурд нь холбогдох ажилтанд өгдөх байх.	<p>Шалгуурыг бүрэн хангасан тохиолдолд</p> <p>Тухайн сард 90-180 хүртэл минутын хоцролтой, эсхүл -оос дээш өдрийн чөлөө авсан бол</p> <p>Тухайн сард 181-ээс дээш минутын хоцролтой, эсхүл чөлөө оролцуулахгүйгээр тухайд сард ажиллавал зохих хугацааны 20-иос дээш хувьд ажиллаагүй бол.</p> <p>Тухайд сард цаг ашиглалтын зөрчлийн улмаас мэдэгдэх хуудас</p>	
			0

Дөрөв. Илэвх санаачилга, багаар ажиллах чадвар, хариуцлага, ёс зүйн байдал		авсан	Нийт авах дээд оноо 10
4.1	Илэвх санаачилгатай, багаар ажиллах чадвартай, хариуцлагатай, ёс зүйтэй байх	Илэвх санаачилга, багаар ажиллах чадвар Ёс зүй, хариуцлагатай байдал	Илэвх санаачилга, багаар ажиллах чадвар 5 хүртэл 5 хүртэл 5 хүртэл
5.1	Тав. Олон нийтийн ажил /Албан хаагчдыг чадавхжуулах дотоод сургалт, өөрийн мэдлэг мэргэшил дээшишүүлэх, спортын арга хэмжээ, нийтийн цэвэрлэгээ үйлчилгээ/-д оролцсон байдал	Олон нийтийн ажил /Албан хаагчдыг чадавхжуулах дотоод сургалт, спортын арга хэмжээ, нийтийг хамарсан цэвэрлэгээ үйлчилгээ, өөрийгөө хөгжүүлж, мэдлэг мэргэшил дээшишүүлсэн байдал/ зэргийг харгалзан	Нийт авах дээд оноо 5 5 хүртэл 5 хүртэл 100 оноо

3. Газрын даргаас албан хаагчид өгч буй зөвлөмж, санал, үүрэг, чиглэл.....

Үнэлгээ өгсөн дарга:
(Д.Батбаяр)
Үнэлгээтэй танилцсан ажилтан:
()